



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Г Сургалт, дадлага зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2.4, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн орон сууцны хорооллуудад гарч байгаа хог, хогийн сувагт гарч байгаа гал түймрийн дуудлагыг бууруулах зорилгоор Сууц Өмчлөгчдийн Холбоодын удирдлага, ажилтнуудад галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, дадлагыг 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд Гал түймэр унтраах, аврах ангиудын сургалтын танхимд зохион байгуулсугай.

2. Сургалт, дадлагын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, дадлагыг зохион байгуулахад шаардагдах 5.760.000 (Таван сая долоон зуун жаран мянган) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалт, дадлагыг удирдамжийн дагуу чанартай, үр дүнтэй зохион байгуулахыг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ СУРГАЛТ ДАДЛАГА,
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн "Сургалт, дадлага зохион байгуулах тухай" А/49 дүгээр тушаалын хэрэгжүүлэх, нийслэлийн орон сууцны хорооллуудад гарч байгаа хог, хогийн суваг, хогийн цэгийн гал түймрийн дуудлагын тоог бууруулах зорилгоор Сууц өмчлөгчдийн холбоодын удирдлага, ажилтнуудад галын аюулаас урьдчилан сэргийлэх, гал гарсан үед цүүрхай арга хэмжээ авах мэдлэг, чадвар олгож дадлагажуулахад оршино.

Хоёр. Сургалт, дадлагыг зохион байгуулах хугацаа, байршил

Сургалт, дадлагыг 2019 оны 05 дугаар сарын 29-нөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд Гал түймэр унтраах, аврах ангиудын сургалтын танхимд зохион байгуулна.

Гурав. Сургалт, дадлагыг зохион байгуулах бүрэлдэхүүн

Нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн нар хамтран зохион байгуулна.

Дөрөв. Сургалт, дадлагын хөтөлбөр

Эхлэх дуусах цаг	Сэдэв	Ноогдох хугацаа	Хариуцах албан тушаалтан
08:40-09:00	Бүртгэл	20 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
09:00-09:15	Сургалтын нээлт	10 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга
09:15-10:15	Галын аюулгүй байдлын тухай хуулиар аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, иргэний хүлээсэн үүрэг	60 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч
10:15-11:15	Нийслэлд гарч буй гамшгийн нөхцөл байдал, гал түймрийн шалтгаан нөхцөл, барилга байгууламжийн галын аюулгүй байдлын талаар	60 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
11:15-12:15	Гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ	60 минут	


	/”олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох “Бэлэн бай” сургалтын багцын “Гал түймэр” сэдвээр/		
12:15-13:00	Хог, хогийн цэг, хогийн сувгийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга замын талаар ярилцлага явуулах	45 минут	Сургалтад оролцогчид
13:00-14:00	Үдийн хоол	60 минут	Томилогдсон алба хаагч
14:00-14:45	Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн талаарх ойлголт, гал унтраагуурыг хэрхэн ашиглах талаар	45 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч
14:45-15:30	Гал унтраах дадлага сургууль явуулах	45 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч нар. Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчид

Тав. Тайлан мэдээ ирүүлэх

Сургалт дадлагын тайланг гэрэл зургаар баримтжуулж, оролцогчдын бүртгэлийн хамт 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдөр нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст ирүүлнэ.

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
 2019 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
 А/49 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардал /материал/-ын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Хоол	хүн	720	6.500	4.680.000
Хэсгийн дүн					4.680.000
Бичиг хэргийн зардал					
1	Дэвтэр	ш	720	1000	720.000
2	Үзэг	ш	720	500	360.000
Хэсгийн дүн					1.080.000
Нийт дүн					5.760.000

---oOo---